



Микро Кредит ББСБ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
хурлын 2023 оны 05 сарын 19-ны өдрийн
23/16 тоот тогтоолын Хавсралт №1 -р батлав.



“МИКРО КРЕДИТ ББСБ” ХХК-ИЙН МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО

Улаанбаатар хот
2023 он

	<p>Мэдээллийн аюулгүй байдлын бодлого</p> <p>Нууцын зэрэг</p> <p>Дотоод</p>	<p>Боловсруулсан:</p> <p>Хянасан:</p>
---	--	---

БАРИМТ БИЧГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

№	БАТАЛСАН ОГНОО	ӨӨРЧЛӨЛТ ОРСОН ЗААЛТУУД	ТОГТООЛЫН ДУГААР
1	2023-05-19	0.1 шинэ хувилбар	23/16

АГУУЛГА

НЭГ. ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ, ХЭРЭГЛЭГЧИД

ХОЁР. ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧИГ

ГУРАВ. МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО

**ДӨРӨВ. МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗОРИЛТ, ТҮҮНД ХҮРЭХ
ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЯНАЛТ ХЭМЖИЛТ**

ТАВ. ЭНЭХҮҮ БАРИМТ БИЧГЭЭС ГАРСАН БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТ

ЗУРГАА. МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ХАРИУЦСАН НЭГЖ

ДОЛОО. БАРИМТ БИЧГИЙН ХҮЧИН ТӨГӨЛДӨР БАЙДАЛ

ЭНЭ
БААТ
ТЭГ
ИТ
ХХК
9 д. 5
ЭНЭ

НЭГ. ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ, ХЭРЭГЛЭГЧИД

Энэхүү бодлогын баримт бичгийн зорилго нь компанийн нөхцөл байдал, сонирхогч талуудын хэрэгцээ шаардлагад үндэслэн мэдээллийн аюулгүй байдлыг хангах цогц тогтолцоог бүрдүүлэхэд баримтлах мэдээллийн аюулгүй байдлын бодлого, хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилт болон түүнд хүрэх төлөвлөгөөг тодорхойлоход оршино.

Энэхүү бодлогын баримт бичиг нь компанийн бүх төрлийн үйл ажиллагаа, түүний мэдээлэл, мэдээллийн системийг ашиглаж байгаа бүх хүнд хамааралтай.

ХОЁР. ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧИГ

- Хөдөлмөрийн дотоод журам
- Албан хэрэг хөтлөлт, Архив, Баримт бичгийн боловсруулах журам,
- Дотоод аудитын журам
- Зээлийн үйл ажиллагааны бодлого
- Компанийн бусад бодлого, дүрэм, журам

ГУРАВ. МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО

Бид харилцагч үйлчлүүлэгчид үзүүлж буй санхүүгийн бүх төрлийн үйлчилгээний мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

Компанийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй харилцагч, түншүүд хамтран ажилладаг байгууллагатай хамтран ажиллахдаа бүхий л мэдээллийн өмч хөрөнгийн нууцлалтай байдал түүний хүртээмжтэй болон бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллана.

Кибер аюулгүй байдлыг хангах, түүнд учирч болох эрсдлийг хамгийн бага байлгах үүднээс ISO 27001 жишиг дээр суурилсан Мэдээллийн Аюулгүй байдлын Менежментийн Тогтолцоог (цаашид МАБМТ гэх) бий болгон тогтвортой мөрдөн, тасралтгүй сайжруулж, холбогдох дүрэм, журмыг мөрдөн ажиллана.

Компаниас үзүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой мэдээлэл, өгөгдөл, оюуны өмч, хөрөнгө оруулагч, хувь хүний мэдээллүүд бүгд үнэ цэнэ бүхий хөрөнгөд тооцогдох бөгөөд уг мэдээлэл устгах, алдагдах, гадны халдлагад өртөх гэх мэт болзошгүй эрсдлийг бууруулж ажиллана.

Мэдээллийн аюулгүй байдал /цаашид"МАБ" гэх/-ыг хангаж, МАБ-ын менежментийн тогтолцоог 2 жил тутам Дотоод аудит шалгаж тасралтгүй сайжруулж ажиллана.

ДӨРӨВ. МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗОРИЛТ, ТҮҮНД ХҮРЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЯНАЛТ ХЭМЖИЛТ

Мэдээллийн аюулгүй байдал /цаашид"МАБ" гэх/-ыг хангаж, МАБ-ын менежментийн тогтолцоог тасралтгүй сайжруулах, МАБ-ын бодлогын хүрээнд дараах зорилтуудыг биелүүлэхийг зорьж ажиллана. Үүнд:

4.1 Мэдээлэл, мэдээллийн систем, дэд бүтэц, программ хангамж, мэдээллийн сүлжээ, түүнчлэн мэдээлэл боловсруулах аппликэйшн, хадгалах өгөгдлийн сан зэрэгт нууцлал, бүрэн бүтэн болон хүртээмжтэй байдалд учирч болзошгүй эрсдлийг тодорхойлох зорилгоор эрсдэлийн үнэлгээг тогтмол хугацаанд хийнэ.

4.2 Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг бууруулахын тулд олон улсын сайн туршлага, стандарт /ISO27001:2013 г.м/ -ыг оновчтой нэвтрүүлэн ажиллана.

4.3 Компани нь үйл ажиллагааг зохицуулагч байгууллагуудаас гаргасан заавал дагаж мөрдөх дүрэм, журам, гэрээний үүрэг ба нөхцөл шаардлагыг бүрэн хангаж ажиллана.

4.4 Мэдээллийн аюулгүй байдлын бодлогын хэрэгжилт нь ажилтан, аутсорсингийн нөөц, сонирхогч талууд, харилцагч, бизнесийн түнш, үйлчилгээ үзүүлэгчдэд мөн хамаарах бөгөөд бодлогын талаарх ойлголтыг өгч, хамтран ажиллана.

4.5 Мэдээллийн аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг үр дүнтэй байлгахын тулд хэмжих үзүүлэлтээр тогтмол хянах, дүн шинжилгээ хийх замаар байнгын сайжруулдаг байна.

4.6 Мэдээллийн аюулгүй байдлын зөрчил/ мэдээлэл задруулах, халдлагад өртөх, луйвар гарах, гэнэтийн осол, давагдашгүй хүчин зүйлс тохиолдох/ үед үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах бөгөөд тайлагналын механизмыг хэрэгжүүлж, ирээдүйд дахин давтагдахаас сэргийлж үндсэн шалтгаанд суурилсан дүн шинжилгээ хийдэг байна.

4.7 Харилцагч, хамтрагч байгууллагын хүлээл, итгэлцэл, сэтгэл ханамжийг дээшлүүлэхийн тулд бүтээгдэхүүн үйлчилгээ, систем, дэд бүтцийн хэвийн тасралтгүй ажиллагааг хангаж ажиллахыг зорино.

№	Зорилт	Хэмжүүр үзүүлэлт	Хэмжих аргачлал	Хүрэх үр дүн	Хариуцах эзэн	Дүгнэх эзэн	Дүгнэх хугацаа
1	Үл тохирлын тоог бууруулах	Үл тохирлын залруулсан арга хэмжээны биелэлт	Хугацаандаа залруулагдаагүй үл тохирлын тоо / Залруулах арга хэмжээ авах үл тохирлын тоог	$\leq 0,1$	Санхүү хэлтсийн захирал	Гүйцэтгэх захирал	Аудитын хөтөлбөрийн хугацаагаар
2	Кибер аюулгүй байдлын үнэлгээг тогтмол хийлгэх	Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийгдсэн байдал	(Тухайн жилд эрсдэлийн үнэлгээ хийгдсэн системийн тоо / хийхээр төлөвлөсөн, шинэчлэлт хийгдсэн системийн тоо) * 100	$\geq 80\%$	МАБ мэргэжилтэн	Гүйцэтгэх захирал	Жил бүрийн 10-р сар
3	Эрсдэл бууруулах төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах	Үйл ажиллагааны эрсдэл бууруулах төлөвлөгөөний хэрэгжилт	Тухайн жилд арга хэмжээ авсан эрсдэлийн тоо / арга хэмжээ авахаар төлөвлөгдсөн эрсдэлийн тоо	$\geq 0,8$	МАБ мэргэжилтэн	Гүйцэтгэх захирал	Жил бүрийн 2-р сар
4	Илэрсэн халдлагад авах хариу арга хэмжээ, хамгаалалтыг нэмэгдүүлэх	Аюулгүй байдлын халдлагын хамгаалалт	Хортой программ хангамжаас үүдэлтэй зөрчил, халдлагын тоо / Системээр илрүүлж хамгаалсан, блокосон халдлагын тоо	$\leq 0,1$	МАБ мэргэжилтэн	Гүйцэтгэх захирал	Жил бүрийн 10-р сар
5	Үйл ажиллагааны системд	Үйл ажиллагааны системд	Тухайн жилд нийт	≤ 6 цаг			Жил бүрийн 10-р сар

	үүсэх догодлыг бууруулах	үүссэн нийт догодлын хугацаагаар	тасалдсан хугацаа		МАБ мэргэжилтэн	Гүйцэтгэх захирал	
6	Ажилтнуудын МАБ-н мэдлэгийг нэмэгдүүлэх	МАБ-ын сургалтад хамрагдсан ажилтнуудын гүйцэтгэлийн хувь	(Тухайн жилд сургалтад хамрагдсан ажилтнуудын тоог / нийт хамрагдах шаардлагатай ажилтны тоо) * 100	>=90 %	МАБ мэргэжилтэн	Гүйцэтгэх захирал	Жил бүрийн 10-р сар

ТАВ. ЭНЭХҮҮ БАРИМТ БИЧГЭЭС ГАРСАН БҮРТГЭЛИЙН ХӨТЛӨЛТ

Бүртгэлийн нэр	Хадгалах байршил	Хариуцах эзэн	Хяналт тавих эзэн	Хадгалах хугацаа
Зорилтын биелэлт, хяналт хэмжилтийн үр дүн	Микрокредит ББСБ төв оффис	МАБ хариуцсан ажилтан	Гүйцэтгэх захирал	3 жил

ЗУРГАА. МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ХАРИУЦСАН НЭГЖ

1. Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан хэлтэс эвсэл мэдээллийн аюулгүй байдал хариуцсан ажилтантай байна.
2. Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан хэлтэс эвсэл мэдээллийн аюулгүй байдал хариуцсан ажилтан нь компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд учирч болох аюулгүй байдлыг урьчилан сэргийлж холбогдох арга хэмжээг тогтмол авч ажиллана.
3. Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан хэлтэс эвсэл мэдээллийн аюулгүй байдал хариуцсан ажилтан Мэдээллийн аюулгүй байдлын зорилт, түүнд

хүрэх төлөвлөгөөг жилийн бүрийн төлөвлөгөөнд тусган батлуулан ажиллана.

4. Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан хэлтэс эвсэл мэдээллийн аюулгүй байдал хариуцсан ажилтан нь ажил гүйцэтгэлийн явц болон гүйцэтгэлээ шууд Гүйцэтгэх захиралд танилцуулах ба шууд удирдлагад нь хамрагдана.
5. Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан ажилтан нь МАБ-н ажилтны ажлын байрны тодорхойлолтын дагуу ажил үүргээ гүйцэтгэн ажиллана.

ДОЛОО. БАРИМТ БИЧГИЙН ХҮЧИН ТӨГӨЛДӨР БАЙДАЛ

Энэхүү баримт бичгийн хүчин төгөлдөр болсон огноо - [2023.05.19].

Гүйцэтгэх захирал нь энэхүү баримт бичгийн эзэмшигч байна. Микрокредит ББСБ нь энэхүү баримт бичгийн өмчлөгч байна. Энэхүү баримт бичгийн хариуцагч нь мэдээллийн аюулгүй байдал хариуцсан ажилтан байна. Хариуцагч нь энэхүү баримт бичгийг жилд нэг удаа эсвэл шаардлага гарсан тухай бүрд нь шинэчлэн сайжруулна.